**ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО**

| ЗОРИЛТ | Хэрэгжүүлэх үйл ажиллагааны тоо | Хэрэгжилт | | | Үнэлэх боломжгүй | Нийт хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | 100% | 70% | 40% | | |
| **НЭГ.** ЗАСАГЛАЛЫН ХҮРЭЭНД | 28 | 20 | 6 | - | 2 | 93 |
| **ХОЁР.** ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭНД | 7 | 5 | 2 | - | - | 91,4 |
| **ГУРАВ.** НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД | 35 | 15 | 14 | 6 | - | 77.7 |
| **ДӨРӨВ.** ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮРЭЭНД | 25 | 14 | 10 | 1 | - | 85,6 |
| **ТАВ.** БАЙГАЛЬ ОРЧИН,ГАЗАР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, УУЛ УУРХАЙН ХҮРЭЭНД | 13 | 11 | 2 | - | -- | 95.3 |
| **ЗУРГАА.**БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХҮРЭЭНД | 10 | 2 | 4 | 4 | - | 64 |
| **ДҮН** | 118 | 67 | 38 | 11 | 2 | 84,5 |

**Нийт хэрэгжилт- 84,5%**

**САЙНЦАГААН СУМЫН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

**2017.06.08.**

| № | Дунд хугацааны бодлогын баримт бичиг | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **ЗОРИЛТ 1.НЭГ.ЗАСАГЛАЛЫН ХҮРЭЭНД** *Зорилго: Төрийн үйлчилгээг зөв зохин байгуулан, хариуцлагатай,чадварлаг төрийн албыг төлөвшүүлж, нээлттэй,ил тод байдлыг ханган, хуулийг хэрэгжүүлэн ажиллана.* | | | | | |
| **1.1.Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах** | | | | | |
| **1** | 1.1.2. | 1.Төрийн албан хаагчдын ажлын байрны сургалтыг тогтмолжуулж, үр дүнг тооцно. | -сургалт төлөвлөгөөний дагуу явагдсан байх | Эхний хагас жилд нийт 263 сургалтанд / орон нутгийн ,бүсийн /сумын ЗДТГазрын 22, боловсролын байгууллагын багш,ажилчид / давхардсан тоогоор 5074 албан хаагч хамрагдлаа. Сургалтанд хамрагдснаар хариуцсан ажлын мэдлэг чадвар, төлөвлөлт,гүйцэтгэл сайжирч байна. | 100 |
| | | 2.Төрийн албан хаагчдаас шинээр болон шинэчлэгдэж байгаа хууль тогтоомжуудаар шалгалт авна. | -шалгалтын тоо,гарсан үр дүн | Байгууллагын албан хаагчдад нийт 13 хуулиар сургалт хийж, шалгалт авлаа. Шинэчлэгдсэн Зөрчлийн тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хуулийг сурталчиллаа.Тестээр 2 удаа шалгалт авч дүгнэлээ. Дүнгийн дундаж хувь 78,9 % байна | 100 |
| | | 3.Төрийн албан хаагчдын Able программын ашиглалтыг улам нэмэгдүүлнэ. | -хандалтын тоо өсөх<br>-ажлын үнэлгээнд оруулна. | Байгууллагын удирдлагууд, албан хаагчид өдөр тутамд Able-ээр ажиллах, 7 хоногийн ажлын төлөвлөгөөг байршуулах үүргийг үр дүнгийн гэрээнд тусган хэрэгжүүлж,тандалтын тоо өмнөх жилээс өслөө. | 70 |
| | | 4. “Сүүн цагаан – Сайнцагаан сонингоор иргэдэд мэдээлэл хүргэх | -сонин сар бүр гарсан байна. | “Сүүн-цагаан Сайнцагаан” сонингийн 1-5 сарын эх бэлтгэлийн ажлыг гүйцэтгэж, “Чөлөөт хэвлэл сан” хэвлэх үйлдвэрт 5000 ш хэвлүүлж, иргэдэд түгээлээ. Сониноор дамжуулан 80 мэдээллийг иргэдэд хүргэлээ. | 100 |
| | | 5.Сумын оны тэргүүнүүдийг шалгаруулж алдаршуулна. | Шагналын журмын дагуу | Засаг даргын зөвлөлийн хурлаар аймаг,сумын засаг даргын шагналаар шагнагдах иргэдийн материалыг хэлэлцэн, Аймгийн засаг даргын шагналд 2 байгууллага, 9 албан хаагчдын тодорхойлолтыг хүргүүлж,сумын тэргүүнүүдийг алдаршууллаа. Тэргүүний хамт олон 2, тэргүүний ажилтан 5, тэргүүний сурагч 1, Сайн малчин 5 гэр бүл, Мянгат малчин 19, Засаг даргын жуух бичгээр 24 албан хаагчдыг шагналаа. | 100 |
| **2** | **1.1.3** | 6.Говийн бүсийн аймгуудтай харилцан туршлага судална. | -туршлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх | Тус сумын ЗДТГазрын албан хаагчид Өмнөговь аймгийн Даланзадгад сумын ЗДТГазартай туршлага судлах арга хэмжээг зохион байгуулж,23 албан хаагч оролцлоо. | 100 |
| **3** | **1.1.4** | 7.Хөдөөгийн багийн нэгдсэн хурлыг зохион | -Хурал зохион байгуулагдсан | Хөдөөгийн багийн нэгдсэн хурлыг 1 удаа байгууллаа.Хурлаар сумын Засаг даргын 2017 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан, “Ногоон-Алт, малын эрүүл мэнд | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | байгуулна. | байна. | төсөл", хурдан морь унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангах, үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хувцас хэрэглэлийн талаар, хог хаягдлын тухай хууль, малтай айлыг аймгийн төвөөс гаргах тухай, газрын харилцааны талаар, сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх зэрэг мэдээллийг холбогдох төрийн албан хаагчид хэлэлцүүллээ. Хуралд нийт 215 малчид оролцлоо. | |
| | | 8.Хөдөөгийн иргэдэд төрийн үйлчилгээг цогцоор хүргэнэ. | -үйлчилгээ хүрсэн байна. | Засаг даргын А/219 тоот захирамжийн дагуу "Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллого явуулах тухай" Захирамжийн хавсралтаар Наран 1, Тэвш 1, Далай 2, Үйзэн 2, Алсын оторт Гурвансайхан, Баянжаргалангийн чиглэлд 1 нийт 7 ажлын хэсэг гарч мал тооллого зохион байгуулах, өвс тэжээлийн захиалга авах, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, сумын сонин хүргэх, цаг үеийн мэдээлэл өгч, цэргийн зарлан хүргэх зэрэг ажлуудаар ИТХ-ын дарга, МЭҮТасгийн дарга, ИТХ-ын тэргүүлэгчид, багийн хүний их эмч нарын бүрэлдэхүүнтэй явлаа.<br>Хөдөөгийн 4 багийн засаг дарга нар 3-4 удаа багийн айл өрхөөр явж,иргэдийн дунд ажиллалаа. | 100 |
| **4** | **1.1.6** | 9.Бараа ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороонд орох эрх бүхий иргэдийн тоог нэмэгдүүлнэ. | - Сертификаттай иргэдийн тоо нэмэгдсэн байна. | Одоогийн байдлаар үнэлгээний хороонд ажиллах эрх бүхий 40 албан хаагчид байна. Цаашид албан хаагч, иргэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Орон нутгийн өмчийн газартай хамтран 3-р улиралд А3 сертификат олгох сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж байна. **/үнэлэх боломжгүй /** | - |
| | | 10.Тендерийн талаарх мэдээллийг иргэд аж ахуй нэгжид тогтмол хүргэнэ. | -Тендерт оролцох ААНэгжүүдийн тоо нэмэгдэнэ. | Сумын ЗДТГ-аас зарлагдсан 18 тендерийг 100 хувь цахимаар зохион байгуулж, мэдээллийг хууль журмын дагуу www.tender.gov.mnсайтанд байршуулан нээлттэй тендер шалгаруулалтын зарыг өдөр тутмын сонинд хэвлүүллээ. Аймгийн ОНӨГазраас зохион байгуулсан цахим тендерт хэрхэн оролцох талаар ойлголт, мэдээлэл олгох сургалтанд 9 аж ахуй нэгжийг хамрууллаа. | 70 |
| **5** | **1.1.8** | 11.Засгийн газрын 01 тоот албан даалгаврыг хэрэгжүүлж, хариуцлагын тогтолцоог мөрдөнө. | - хуулийн дагуу хариуцлага тооцох | Байгууллага бүр ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүллээ. Энэ арга хэмжээний хүрээнд албан хаагчдын ажлын цагт хяналт тавих,ажлын гүйцэтгэлийг 7 хоног бүр дүгнэх, хугацаатай мэдээний чанарт анхаарлаа. Ингэснээр ажлын бүтээмж нэмэгдэж байна. | 100 |
| | | 12.Орон нутгийн татварын орлогын бүрдүүлэлтэнд албан хаагчдын үүрэг хариуцлагыг дээшлүүлнэ. | -Орон нутгийн орлого биелэнэ | Албан хаагчдын үр дүнгийн гэрээнд орон нутгийн орлогын татвар бүрдүүлэх заалтыг тусгаснаар багийн засаг дарга нар нохой муурны татвар 673,0, худалдаа үйлчилгээний мэргэжилтэн төлбөр хураамж 13,679,500 төвлөрүүлж, Орон нутгийн орлого төлөвлөгөө 91,561.9 мянган төгрөгөөс 111,251.4 мянган төгрөг төвлөрүүлж, 121 хувийн биелэлттэй байна | 100 |
| **1.2.Хууль ёсыг бэхжүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх** | | | | | |
| **6** | **1.2.2**. | 13.Иргэдийн оролцоонд тулгуурлан хууль эрх зүйн ажлыг тогтмолжуулна. | -ТАХаагч, иргэдийн эрх зүйн боловсрол нэмэгдэнэ. | Багийн ИНХурал, Хууль эрх зүйн 10 нэр төрлийн сургалтыг давхардсан тоогоор 876 иргэнд хүргэлээ. Болзошгүй гал түймрээс урьдчилан сэргийлэх, галын аюулгүй байдлыг хангах сургалтад-112 иргэн, Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх таслан зогсоох-78 иргэн, Цагдаагийн газар болон хүний эрхийн | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | байгууллагын хамтарсан хуулийн мэдлэгийг нэмэгдүүлэх сургалтад 83 иргэн Зөрчлийн тухай хууль-168, ГХУС-лэх тухай хууль-125, Хүүхэд хамгааллын тухай хууль-96 Хог хаягдлын тухай хууль-138, Өрх толгойлсон эхэд мөнгөн тэтгэмж олгох тухай-76 иргэнд хуулийн мэдлэг олголоо. | |
| | | 14.Төвийн багийн нээлттэй өдөрлөгийг зохион байгуулна. | -иргэдийн оролцоог баг бүрээр тооцох | Төвийн 5 багийн Нээлттэй мэдээллийн өдөр боллоо. Өдөрлөгт сумын удирдлагууд, багийн засаг дарга нар, мэргэжилтнүүд оролцож иргэдэд мэдээлэл хийж, Говийн гэгээ ХХК, Оргил бейкери бүтээгдэхүүний дээжээр амталгаат худалдаа хийлээ. Мөн сумын болон Өлзийт Мандал өрхийн ЭМТөв, Хуульч өмгөөлөгчдийн холбооны өмгөөлөгчид, ГБХЗХГазрын мэргэжилтнүүд, Нийгмийн даатгалын хэлтэс оролцож, 300 гаруй иргэдэд төрийн үйлчилгээ хүргэж,иргэдтэй уулзлаа.Баг тус бүр 60 гаруй иргэдэд мэдээлэл хүргэлээ. | 100 |
| **7** | **1.2.3** | 15.Сумын авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | -хөтөлбөр гарсан байх | Сумын Авлигатай тэмцэх хөтөлбөрийг ЗД-ын А/29 тоот захирамжаар батлуулж, цахим хуудас, самбарт байрлуулж сурталчиллаа. Хөтөлбөр 90. 5 хувьтай хэрэгжлээ. | 100 |
| | | 16. Албан тушаалтны ХАСын болон ХОМэдүүлгийг хуулийн хугацаанд гаргаж цахимд байршуулна. | Хуулийн хугацаанд бүртгүүлсэн байх | ХАСХОМ гаргах 18 албан тушаалтны мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулан баталгаажуулж,цахимд байршууллаа. | 100 |
| | | 17.Нийтийн албанд нэр дэвшсэн этгээдийн ХАСУМэдүүлгийг бүрэн хянуулж, ашиг сонирхлын зөрчилгүй томилгоог хэвшүүлнэ. | Хуулийн хугацаанд хянуулж, дүгнэлт гаргасан байх | Эхний хагас жилд сумын засаг даргын орлогч, Мандал сургуулийн сургалтын менежерийн /2 албан хаагчийн / ХАСУМэдүүлгийг Авилгатай тэмцэх газарт хянуулж,дүгнэлтийг авч албан тушаалд томиллоо.<br>ХАСХОМэдүүлгийг 2 албан хаагч / Мандал сургуулийн менежер, 7-р цэцэрлэгийн эрхлэгч /30 хоногийн дотор гарган баталгаажууллаа.<br>ЭБАТушаалтны цэсний бүртгэлд тухай бүр хууль,журмын дагуу бүртгэлээ. | 100 |
| **8** | 1.2.4. | 18. Харьяа байгууллагуудын удирдлагуудын шийдвэрүүдийг хянаж зөвлөмж хүргүүлнэ. | -бичиг хэргийн стандартыг мөрдүүлэх | Харъяа байгууллагын удирдлагын гаргасан тушаал шийдвэрийг хагас жилд хянан зөвлөмжийг хүргүүлж, байгууллагын 21 албан хаагчдад архив албан хэрэг хөтлөлтийн талаарх сургалтыг явууллаа. | 100 |
| | | 19. Байгууллагуудын баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлж,мэдээллийн сан бүрдүүлнэ. | -цахим хэлбэрт харьяа байгууллагууд шилжсэн байх | Байгууллагын 2003-2016 онуудын захирамж тушаалыг сканердаж цахимжууллаа.Албан хаагч бүр баримтыг хагас жил бүр архивын нэгж үүсгэн архивт өгч байна. | 100 |
| **1.3.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх** | | | | | |
| **9** | **1.3.1** | 20.Багийн иргэд, олон нийтийн эргүүл, хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын уялдаа холбоог сайжруулна | -гэмт хэрэг буурсан байх | Гэмт хэрэг зөрчилгүй баг аяны хүрээнд төвийн 5 баг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө гарган иргэд хэсгийн төлөөлөгч нартай хамтран олон нийтийн эргүүлийг 7 хоногт 2 удаа гаргаж хэвшээд байна. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 21.Архины хамааралтай иргэдийн дунд арга хэмжээ зохион байгуулна. | -иргэдийн хамрагдалт | Сумын хэмжээнд 58 архины хамааралтай иргэдийн судалгааг гаргаж “Говийн хийморь” АА бүлгийн 2 удаагийн уулзалт цуглаанд 16 иргэнийг хамруулаа. Одоогийн байдлаар 5 иргэн тус бүлэгт идэвхитэй хамрагдаж бусаддаа нөлөөлөх ажлыг хийж байна. | 70 |
| | | 22.Гэмт хэрэг зөрчилгүй баг шалгаруулна. | -хөдөө,төвөөс тус бүр 1 багийг шалгаруулах | Тус сумын ИТХурлаас “Гэмт хэрэг зөрчилгүй баг” аяныг зохион байгуулж, төвийн 5 баг ГХУСэргийлэх ажлын төлөвлөгөөний дагуу ажиллаж, ГХУСАЗ-ийн дэд зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгууллаа. Шалгаруулалт 4-р улиралд болно. **/үнэлэх боломжгүй /** | - |
| **10** | **1.3.3** | 23. Эцэг эхийн төлөөлөлтэй хамтран Олон нийтийн эргүүлийг хуваарийн дагуу ажиллуулна. | -Эргүүлд оролцсон иргэдийн тоо | “Эцэг эх–зохицуулагч” эргүүлийг өдөр бүр гаргаж, сар бүр 364 эцэг эх хамрагдлаа. Цагдаагийн газартай хамтран хуваарийн дагуу 36 багш, нийгмийн ажилтан, сургалтын менежер хариуцлагатай эргүүлд гарлаа. Сургууль төгсөгчдийн баяраар сурагчдад сургуулийн дотоод дэг журмыг зөрчихгүй байх талаар ярилцлага хийж, сургуулийн орчинд багш нарын жижүүрийн цагчилсан хуваарийг гаргаж зөрчил гаргахаас урьдчилан сэргийллээ. | 100 |
| | | 24.Эрх зөрчигдсөн хараа хяналтгүй хүүхэдтэй ажиллахад ТББайгууллага эцэг эх,асран хамгаалагчийг оролцуулж, дэмжлэг үзүүлнэ. | -хамтран ажилласан иргэд,хүүхдийн тоо | Хүүхдийн тусламжийн 108 утсанд мэдээлэл ирсэний дагуу 4 өрхийн 7 хүүхдэд кейс нээн төлөвлөгөө гарган ажиллаж байна. Үүнд: Хараа хяналтгүй-1, эрх нь зөрчигдсөн хүчирхийлэлд өртсөн-6 хүүхэд байна.<br>Төвийн 5 багийн хараа хяналт сул, огт хараа хяналтгүй 10 өрхийн 10 хүүхдэд Дэлхийн зөн ОНХХ-тэй хамтран дулаан хувцас, тусламж зайлшгүй шаардлагатай Арвижих багийн 3 өрхөд шинээр гар угаалтуур, Айраг багийн 2 өрхөд 5 ханатай гэрийн дэмжлэг туслалцаа үзүүллээ. | 100 |
| **1.4.Батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх** | | | | | |
| **11** | **1.4.1** | 25.Цэрэг татлагыг хуулийн хугацаанд зохион явуулах, иргэдийг бүрэн хамруулах | -Хамрагдсан иргэдийн тоо | Цэрэг татлагыг 1 удаа явуулж, цэргийн насны нийт 138 иргэнийг хамруулаа. Цэргийн жинхэнэ албанд 18 цэрэг тэнцэж, Дорноговь, Өмнөговь,Улаанбаатар хотод хуваарилагдлаа. Ихэнх цэргийн насны залуус өвчнөөр чөлөөлөгдөж байна.<br>Цэргийн насны 100 гаруй залууст цагдаагийн хэсгийн байцаагчтай хамтран “Зөрчлийн тухай хуулиар сургалт мэдээлэл хийлээ.Цэргийн насны иргэдийн эрүүлжүүлэх арга хэмжээг сумын 3 өрхийн ЭМТөвүүд нэрсийн дагуу зохион байгуулж байна. | 70 |
| | | 26.Төрийн байгууллагуудад батлан хамгаалах бодлогын хэрэгжилтийг шалгана. | -Хяналт шалгалт хийгдсэн байна. | Харьяа байгууллагын цэргийн насны эрэгтэйчүүдийн судалгааг гаргууллаа. Судалгаанаас үзвэл цэргийн насны иргэдийн 30 % нь цэргийн жинхэнэ алба хаасан иргэд байна. Багш нарын ихэнх хувь нь мөнгөн төлбөрөөр цэргийн албыг хаалаа.Энэ оны эхний хагас жилд 25 иргэнд мөнгөн төлбөр тогтоолоо. Сумын төвд үйл ажиллагаа явуулж байгаа ААНэгж байгууллагын батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг харьяа байгууллагад зохион явуулж,зөрчилтэй 8 албан хаагчид мэдэгдэл өглөө. | 100 |
| | | 27.Цэргийн тоо бүртгэлийг чанартай зохион байгуулна. | Иргэдийн 80%ийг хамруулна. | Цэргийн бүртгэлийг оны эхэнд зохион байгуулж, нийт иргэдийн 68,5 хувь нь бүртгэлд хамрагдлаа. Хамрагдаагүй шалтгааны ихэнх хувийг хаягандаа байхгүй иргэд эзэлж байна. Хөдөөгийн багийн иргэд бүртгэлд хангалттай сайн хамрагдлаа. | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **12** | 1.4.3. | 28.Сумын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангид тодотгол хийх,бэлэн байдлыг хангана. | -тодотгол хийгдсэн байх | Сумын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг шинэ дүрмийн дагуу тодотгол хийж,томилгоожуулллаа. Төвийн сум учраас мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн 90 хүнтэй байхаар шинээр байгууллаа | 100 |
| **ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭНД**<br>***Зорилго:Эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, "Шилэн данс"ны хуулийг бүх шатанд хэрэгжүүлнэ.*** | | | | | |
| **2.1.Эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх** | | | | | |
| **1** | 2.1.1. | 1.Судалгааны дагуу хөрөнгөөс хасах, засварлах ,худалдах асуудлыг шийдвэрлэнэ. | -шийдвэрлэсэн хөрөнгийн тоо | Аймгийн ОНӨГазарт ашиглахгүй байгаа ЗДТГ-ын 3 нэр төрлийн 50,245.0 мян төгрөгийн хөрөнгийн судалгаа гаргаж,сумын ИТХ урлаар ЭДЦСургуулийн 3 нэр төрлийн 6346.5 мян төгрөгийн тавилга эд хогшлийг орлогодох санал оруулж шийдвэрлүүллээ. Мөн 1 сургуулийн 2 нэр төрлийн 13,372.1 мян төгрөгийн тавилга эд хогшил, 5 цэцэрлэгийн 1,233.6 мян төгрөгний тавилга эд хогшил, 898.1 мян төгрөгийн тоног төхөөрөмжийг актлуулахаар, 2307.1 мян төгрөгийн тавилга эд хогшлийг орлогодуулахаар Сумын ИТХ-д материалаа өглөө. | 70 |
| **2** | 2.1.2 | 2.Дуудлага худалдаагаар зарим газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулна. | -орлогод хөрөнгө төвлөрнө. | Энэ онд 1 иргэнд 0,12 га газрыг үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар мандал багт эзэмшүүллээ. Орон нутгийн орлогод 2,160,0 төгрөг төвлөрүүллээ. | 100 |
| **2.2.Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах** | | | | | |
| **3** | **2.2.1.** | 3.Хуулийн хэрэгжилтийг ханган өдөр тутмын гүйлгээг хянан баталгаажуулах , дамжуулах | Санхүүгийн Freebalance программ ашиглана. | Төрийн сангийн үйл ажиллагааны журмыг / ЗГ-ын 2015 оны 24-р тогтоол / баримтлан төлбөр тооцоог гүйцэтгэхдээ Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн цахим сүлжээний Freebalance программ ашиглан төрийн сангийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж, 1-5 сард харъяа төсөвт 15 байгууллагын 68 дансаар нийт 3116ш төлбөрийн хүсэлтээр 3,669,479.5 мян төгрөгний гүйлгээ шивж гүйцэтгэн хянан баталгаажуулж дамжууллаа.Өдөр тутмын гүйлгээний хяналтыг тухай бүр хийж, заавар, зөвлөмжийг өгч санхүүгийн удирдлагаар хангалаа. | 100 |
| **4** | **2.2.2.** | 4.Төсөвт байгууллагуудыг төсвийн зарцуулалт, санхүүгийн ил тод байдлыг албан хаагчид, ТББайгууллагаар үнэлгээ хийлгэнэ. | Үнэлгээ хийгдсэн байх | Төсвийн ерөнхийлэн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан аудитлагдаж зөрчилгүй санал дүгнэлт авлаа.<br>Тус тайланг харъяа төсөвт 15 байгууллага 7 санг аудитлагдаж санхүүгийн тайланг нэгтгэлээ. Байгууллага бүр Шилэн дансны хуулийг бүрэн хэрэгжүүллээ | 100 |
| **5** | 2.2.3. | 5.Төсвийн шууд захирагч нарын үр дүнгийн гэрээнд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг тусгах, үр дүнг тооцох | -Хуулийн хэрэгжилт сайжирна. | Шилэн дансны мэдээлэл байршуулах самбарыг шинэчлэн мэдээллүүдийг тухай бүр сольж байна. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төсвийн мэдээллээ хуулийн хугацаанд байршуулж илгээлээ. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **6** | **2.2.4.** | 6.Багийн засаг дарга, Улсын байцаагч, татварын байцаагч нарын хамтын үйл ажиллагааг сайжруулах | Гэрээнд тусгах | Татварын байцаагч, ХҮ-ийн мэргэжилтэн, сумын цагдаагийн төлөөлөгч, Стандарт хэмжилзүйн хэлтсийн мэргэжилтэн нартай хамтран үсчин гоо сайхны газруудаар явж хяналт хийж сургалт зохион байгуулан татварын орлогыг жигд биелүүлэхэд анхаарч 234,0 мян төгрөгний ХХОАТатвар төвлөрүүллээ.<br>Байгаль орчны хяналтын улсын байцаагч, багийн засаг дарга нартай хамтран хог хаягдлыг бууруулах,цэвэрлэх, ногоон байгууламжийг хамгаалах талаар хамтран ажиллаж илэрсэн зөрчлийг шийдвэрлэлээ. | 70 |
| | | 7.Татварын орлогыг биелүүлэх сарын аян тухай бүр зохион байгуулах | Орлого төлөвлөгөөний дагуу төвлөрөх | Сар бүр татварын орлогыг биелүүлэх аяны зохион байгуулсанаар эхний хагас жилд орон нутгийн орлогод 111,251.4 мянган төгрөг төвлөрүүлж, 121 хувийн биелэлттэй байна. | 100 |
| **ГУРАВ.НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**<br>***Зорилго:Иргэдийн эрүүл аюулгүй орчинд сурч, хөгжих, ажиллаж , амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн үйлчилгээнд тэгш хүртээмжтэй хамрагдах боломжийг бий болгох замаар хүний хөгжлийг дээдэлнэ*** | | | | | |
| **3.1. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах** | | | | | |
| **1** | **3.1.1.** | 1.Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт иргэдийг бүрэн хамруулах | -Эрүүлжилт тооцсон ажилчдын тоо | Сумын Эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлсэн нийт 5554 иргэдээс урьдчилан сэргийлэх үзлэгт 2826 иргэн, үүнээс:Өвчний учир 782, Диспансер хяналт 910, Гэрийн идэвхтэй эргэлт 812, Дуудлагаар 214, Алсын дуудлагаар 122 хамруулж Артерийн гипертинзи-419, Чихрийн шижин үзлэг-419, Хөхний үзлэг-377, Рар шинжилгээ151 хүн илрүүлж, нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд эрүүлжилт тооцон ажиллаж байна.<br>-Багийн эмч нар шүлхий өвчний өндөржүүлсэн бэлэн байдлын үед хөдөөгийн багийн айл өрхөөр явж урьдчилан сэргийлэх үзлэгт 61 иргэн хамруулж үүнээс артерийн даралт ихсэлттэй 8, томуу томуу төст өвчтэй 5, ХБИ 7, бөөр шээсний замын эмгэгтэй 3 хүн өвчтэй байсанд эмийн эмчилгээ болон зөвлөгөө өглөө. | 70 |
| | | 2.Сүрьеэ БЗДХ-ын илрүүлэг үзлэг,шинжилгээг эрчимжүүлнэ. | -эрт оношлогдсон байх | Хагас жилийн байдлаар сүрьеэгийн 10 сэжигтэй тохиолдлын цэрний шинжилгээг зөөвөрлөж өвчтэй тохиолдол илрээгүй.<br>Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх гарын авлага нийт 100 ширхэгийг ЭМТ-өөр үйлчлүүлж байгаа иргэдэд тараалаа. Мандал худалдааны төвийн гадна талбайн LED дэлгэцээр сүрьеэ өвчнөөс сэргийлэх шторкыг иргэдэд сурталчиллаа.<br>“Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлье” сэдэвт сургалтыг нийт 96 иргэнд зохион байгуулж, Эрүүл цус аяны хүрээнд нийт 505 хүнээс сорьц авч үүнээс тэмбүү өвчтэй 17 оношлогдож нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд эмчилгээг 100% хийлээ.<br>Мандал сургууль, 1,2,4-р цэцэрлэгийн 75 ажилчдад "Эрүүл амьдрах алхамууд" төлөвлөгөөт сургалтад хамруулж, БЗДХӨ/ДОХ-оос сэргийлэх, эмийн зохистой хэрэглээ зэрэг сэдвүүдээр сургалт хийлээ.<br>ЭДЦС-ийн сургуулийн эмч, дотуур байрын 2 багштай хамтран 14-оос дээш насны охид хөвгүүдэд “Архи тамхи мансууруулах” бодисын хэрэглээ ба БЗДХӨ-өөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж нийт 110 хүүхдийг үзлэгт хамрууллаа. | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 3.Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн хувийг сумын хэмжээнд нэмэгдүүлэх | Өмнөх оноос дундаж үзүүлэлт өснө | Зонхилон тохиолдох халдварт бус өвчний артерийн даралт ихсэлт 1049 хүн хамрагдахаас 419 буюу 39,9%, чихрийн шижингийн эрт илрүүлэгт 1100 хүн хамрагдахаас 419 буюу 37,4% хамрагдлаа.<br>Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн хөхний үзлэгт орох 822 эмэгтэй хамрагдахаас 370 буюу 45,8%, умайн хүзүүний эсийн шинжилгээнд 293 хүн хамрагдахаас 151 хүн буюу 50,6% хамрагдлаа. | 40 |
| **2** | **3.1.2.** | 4.Жирэмсний хяналтанд эхчүүдийг 100 хувь хамруулж, эрт хяналтыг сайжруулна. | -Хяналт тогтмолжсон байх | Эний 5 сарын байдлаар 49 жирэмсэн эхийг хяналтанд авснаас эрт хяналт 46 буюу 93,8 % байна. | 100 |
| | | 5.Эх хүүхдийн өвчлөлийг бууруулж, эх хүүхдийн эндэгдэлгүй ажиллана. | -эндэгдэл гараагүй байх | Эх хүүхдийг агаар дуслын замын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Дэлхийн зөн ОУБайгууллагаас дэмжсэн тус бүр нь 750.000 төгрөгийн үнэ бүхий агаар цэвэршүүлэгч 2 -ыг урд, хойд хүлээлгийн танхимд байрлууллаа. Нөхөн дархлаажуулалтанд нийт 65 хүүхэд хамрагдсанаас тавт вакцинд 10, халдварт саагийн вакцинд 10, ВГА вакцинд 21, УГУ вакцинд 20 хүүхдийг хамруулаа. Эх нярайн эндэгдэлгүй байна. | 100 |
| | | 6.Хүүхдийн шүдний өвчлөлийг бууруулах, эрүүлжүүлэх | Эрүүлжүүлэлтийн хувь тооцсон байна. | Цэцэрлэгийн хүүхдүүдэд өсөлт жинлэлт болон шүдний үзлэг хийж, 1-р цэцэрлэгийн нийт 98 хүүхдээс 20 хүүхэд, 6-р цэцэрлэгийн нийт 216 хүүхдээс 48 хүүхэд 2 ба түүнээс дээш шүд хорхойтой илрүүлж, цэцэрлэгийн эмчид эрүүлжилт тооцон ажиллахыг санал болголоо. | 70 |
| **3** | **3.1.7.** | 7.Шинэ суурьшлын бүс Мандал багийн 15 дугаар гудамжинд усан сан бий болгоно. | Усан сан бий болсон байх | Засаг даргын А/91 тоот захирамжийн дагуу усан сан бий болгох үнэлгээний хороо байгуулагдан тендерийг зарлан холбогдох газарт дүгнэлтийг хүргүүллээ. | 40 |
| **4** | **3.1.8.** | 8.Усны хэрэглээний талаар сургалт явуулж,ус ууж хэвших хөдөлгөөн өрнүүлнэ. | Хөдөлгөөнд оролцогчдын тоо | Дэлхийн усны өдрийг тохиолдуулан Мандал худалдааны төв болон эрүүл мэндийн төвийн ТВ-ээр “Ундны усны эрүүл ахуй”, ”Орчны эрүүл ахуй” сэдэвтэй 2 төрлийн 5 минутын эрүүл мэндийн шторкыг 5 өдрийн турш явуулж иргэдэд сурталчиллаа. | 40 |
| | | 9.Ундны усны хуванцар савны хэрэглээний талаарх мэдлэгийг иргэдэд мэдээлэл сургалт суртчилгаа явуулна. | Стандартын сав хэрэглэгчийн тоо | Ундны усны хэрэглээ сэдэвт аяныг 2 зорилтын хүрээнд 21 хоногийн хугацаатай усны эрүүл ахуйн 7 дадал, хуванцар савны хэрэглээ сэдвийн дор тэмдэглэн өнгөрүүллээ. 1-р зорилтын хүрээнд: нийт 3 төрлийн 80 гаруй ширхэг гарын авлагыг боловсруулж иргэдэд тарааж, аймгийн төвийн 15 худагт байрлууллаа.<br>2-р зорилтын хүрээнд: сумын гэр хороололд оршин суудаг 40 иргэдэд “Ундны усны чанар, аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдэвт сургалтыг зохион байгуулж, сургалт сурталчилгааны материалыг тараалаа. | 70 |
| **5** | **3.1.10.** | 10.Малчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж,өвчлөлийг бууруулна. | -малчдын 80-аас дээш хувийг хамруулна. | Эмэгтэйчүүдийг халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгт 67 эмэгтэй хамруулаа. Үзлэгийн үр дүнгээс артерийн даралт ихсэлт, чихрийн шижингийн илрүүлэг үзлэгт 50, хөхний үзлэгт 21, умайн хүзүүний эсийн шинжилгээнд 15, элэгний В, С вирусын шинжилгээнд 2 орж өөрчлөлттэй гарсан тохиолдол байхгүй. Хөдөөгийн багийн 1849 иргэн урьдчилан сэргийлэх үзлэгт | 40 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | хамрагдаж,нийт үзлэгийн 33,2%-ийг эзэлж байна. | |
| **3.3.Биеийн тамир,спортын арга хэмжээнд иргэдийг хамруулах** | | | | | |
| **6** | 3.3.4. | 11.Төрийн албан хаагчдын дунд уралдаан тэмцээн зохион байгуулна. | -тэмцээний тоо,<br>-оролцсон ТАХ-дын<br>тоо | Сумын ЗДТГазраас санаачлан ЭДЦСургууль, Улсын тэргүүний 3-р цэцэрлэг хамтран сумын харьяа төсөвт байгууллагуудын ажилтан албан хаагчдын дунд волейболын тэмцээн зохион байгууллаа. Тэмцээнд ЕБСургуулийн 10, цэцэрлэгийн 3, ЗДТГ-ын 2,нийт-15 багийн 120 албан хаагч оролцлоо. Шагналын санд 450,000 төгрөг зарцууллаа. | 100 |
| | | 12.Ажлын байрны дасгалыг тогтмол хийж хэвшинэ. | Нийтийн биеийн тамирыг хөгжинө. | Сумын нийт төсөвт байгууллагын 578 албан хаагч хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулан, ажлын байрны дасгалыг хамт олноороо хийж, тогтмолжуулллаа.<br>Мөн 30 минутын турш идэвхтэй хөдөлгөөнийг хийж хэвшүүлэхээр аэробекийн 16 тоот хөдөлгөөнийг хөгжмийн аянд тогтмол хийж байна. | 70 |
| | | 13.Оюутан залуучуудын дунд 3 төрлийн спортын тэмцээн явуулна. | Багийн идэвх оролцоо | Тэмцээнийг волейбол, теннис, дартс гэсэн 3 төрлөөр 9 багийн оюутан залуучуудын дунд зохион явууллаа. Тус тэмцээнд 9 багийн нийт 212 тамирчид оролцож, нийт дүнгээр Нарлаг багийн тамирчид тэргүүн байр эзэлж цомын эзэд боллоо. Тэмцээний нийт зардалд 939,000 төг зарцууллаа. | 100 |
| **3.5.Гэр бүл,хүүхэд,залуучуудын оролцоо,хөгжил,сайжруулах** | | | | | |
| **7** | **3.5.1.** | 14.Хамгаалал шаардлагатай гэр бүлийн судалгааг гаргана. | Судалгаа гарсан байна. | Сумын хэмжээнд хамгаалал шаардлагатай 86 өрхийн нарийвчилсан судалгааг гаргалаа. | 100 |
| | | 15.Байгууллагуудын хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааг дэмжих, үр дүнг тооцно. | -үйл ажиллагааны тоо,чанар | Байгууллагаын хүүхэд хамгааллынбагийн гишүүд үйл ажиллагааг зохион байгуулж, хүүхдийн баяраар байгууллага бүр хүүхдүүддээ бэлэг гардуулж, хүндэтгэл үзүүллээ. Үйл ажиллагааны төсвийн 50 %-ийг тухайн байгууллага хариуцлаа. | 70 |
| | | 16.Хүүхэд хамгааллын сургалтыг эцэг эхчүүд, багш, байгууллагын ажилчдад зохион байгуулна. | Үе шаттайгаар зохион явуулна | Хүүхэд хамгааллын төлөвлөгөөний дагуу хүүхэд, эцэг эх багш нарт сургалт зөвлөгөө, зөвлөмжийг өгч төрөл бүрийн үйл ажиллагаа зохион байгууллаа. Нийт тэмцээн уралдаан-1, өдөрлөг-2, сургалт хэлэлцүүлэг-17 зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 2340 эцэг эх, хүүхдийг хамрууллаа. | 100 |
| **8** | **3.5.5.** | 17.Хүүхэд хамгааллын бодлогыг боловсруулж батлуулж, хэрэгжүүлнэ. | ХХ-ын бодлоготой болно. | Хүүхэд хамгааллын сумын бодлогыг шинээр боловсруулж байна. Хамтарсан багийг чадавхжуулах 2 өдрийн сургалтанд хамруулж кейстэй ажиллах чадвар, дадлагатай болголоо. Халамж анхаарал шаардлагатай 4 хүүхдэд кейс нээн ажиллаж байна. | 40 |
| | | 18.Бүтэн өнчин хүүхдэд хүндэтгэл үзүүлнэ. | Хүүхдүүдийг бүрэн хамруулах | Сумын бүтэн өнчин 15 хүүхдийг хүүхдийн баяраар хүлээн авч хүндэтгэл үзүүллээ. Хүндэтгэлийн үйл ажиллагаанд 265750 төгрөг зарцууллаа. | 100 |
| | | 19.Дугуйн уралдааны зохион байгуулах | Уралдаан зохион байгуулагдана. | Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр 6 насны ангиллаар дугуйн уралдааныг зохион байгуулж, 119 хүүхэд оролцлоо. Насны ангиллаар эхний 3 байрыг шалгаруулж, нийт 18 хүүхдийг “Хас” банктай хамтран шагналаа | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **9** | **3.5.6.** | 20.”Шилдэг хүүхэд -2017 арга хэмжээг зохион байгуулна. | Шилдэг хүүхдийн тоо | Ерөнхий боловсролын 5 сургуулийн 9,12 дугаар ангийн 26 бүлгийн 724 төгсөгчдийн эрдмийн баярыг зохион байгууллаа. “Шилдэг хүүхэд-2018” шагналаар сурлага, урлаг, спортоор манлайлсан сургууль тус бүрээс шалгарсан 5 сурагчийг шагналаа. | 100 |
| | | 21.“Алтан төлийн эзэн” шалгаруулна. | -журмын дагуу шалгаруулна | Сумын Алтан төлийн эзнээр : "Алтан ботго" Үйзэн багийн малчин С.Отгонбаатар,"Алтан унага" Наран багийн малчин Д.Раднаабазар ,"Алтан тугал" Далай багийн малчин Д.Төмөрбаатар ,"Алтан хурга" Тэвш багийн малчин Ү.Чимэд-Очир ,"Алтан ишиг" Наран багийн малчин Ш. Болдбаатар нар шалгарлаа. | 100 |
| | | 22.Төлчин эмэгтэйчүүдийн зөвлөгөөнийг зохион байгуулна. | Зөвлөгөөн зохион байгуулсан байх. | Сумын төлчин эмэгтэйчүүдийн IV-р зөвлөгөөнийг зохион байгуулж, хөдөөгийн 4 багаас нийт-151 төлчин эмэгтэй оролцлоо.<br>Хөтөлбөрийн дагуу сумын ЭМТөвтэй хамтран төлчин эмэгтэйчүүдийг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамрууллаа. Үйл ажиллагааны үеэр сумын засаг дарга 2017 онд хийгдсэн ажлын тайлан, 2018 онд хэрэгжүүлэх ажлын талаар танилцууллаа. Зөвөлгөөнд сумын ЗДТГазраас санаачлан харъяа төсөвт байгууллагуудын дунд “Сайн үйлсийн аян” өрнүүлэн 3.5 сая төгрөгний бараа бүтээгдэхүүнийг зорилтот бүлгийн 16 малчдад гардууллаа. | 100 |
| **3.6.Хөдөлмөр эрхлэлт ,нийгмийн хамгааллыг нэмэгдүүлэх** | | | | | |
